Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын мэргэжлийн нэр томъёоны тайлбар толь

Англи-Монгол

English	Mongolian
Add value The internal audit activity adds value to the organization (and its stakeholders) when it provides objective and relevant assurance, and contributes to the effectiveness and efficiency of governance, risk management, and control processes.	**Үнэ цэн нэмэх** Дотоод аудитын нэгж бодитой бөгөөд учир холбогдолтой баталгаа өгч, засаглал, эрсдэлийн удирдлага ба хяналтын үйл явцын үр ашиг, үр нөлөөнд хувь нэмэр оруулж байвал байгууллагад (болон түүний сонирхогч талуудад) үнэ цэн нэмдэг.
Adequate control Present if management has planned and organized (designed) in a manner that pro vides reasonable assurance that the organization's risks have been managed effectively and that the organization's goals and objectives will be achieved efficiently and economically.	**Зохистой хяналт** Хэрэв удирдлагын зүгээс байгууллагын эрсдэлүүд үр нөлөөтэй удирдагдаж, байгууллагын зорилго, зорилтууд ур ашигтай, хэмнэлттэй биелэгдэнэ гэсэн үндэслэлтэй баталгаа өгөхүйц байдлаар төлөвлөж , зохион байгуулсан (зохиомжилсон) бол зохистой хяналт байна.
Assurance services An objective examination of evidence for the purpose of providing an independent assessment on governance, risk management and control processes for the organization. Examples may include financial, performance,	**Баталгаажуулах үйлчилгээ** Хэрэв удирдлагын зүгээс байгууллагын эрсдэлүүд үр нөлөөтэй удирдагдаж, байгууллагын зорилго, зорилтууд үр ашигтай, хэмнэлттэй биелэгдэнэ

compliance, system security, and due diligence engagements.	гэсэн үндэслэлтэй баталгаа өгөхүйц байдлаар төлөвлөж, зохион байгуулсан (зохиомжилсон) бол зохистой хяналт байна.
Board A board is an organization's governing body , such as board of directors, supervisory board, head of an agency or legislative body, board, board of governors or trustees of nonprofit organization , or any other designated body of the organization, including the audit committee to whorm the chief audit executive may functionally report.	**Зөвлөл** Захирлуудын зөвлөл , хянан удирдах зөвлөл , агентлагийн буюу хууль тогтоох байгууллагын дарга , ашгийн бус байгууллагын захирагч нарын буюу эсвэл итгэмжлэгдсэн этгээдүүд , байгууллагын бусад томилогдсон этгээд , түүний дотор аудитын гүйцэтгэх удирдлага чиг үүргийнхээ хувьд тайлагнах аудитын хороо гэх мэт аливаа байгууллагын засаглах байгууллагыг зөвлөл гэнэ .
Charter The internal audit charter is a formal document that defines the internal audit activity's purpose, authority, and responsibility. The internal audit charter establishes the internal audit activity position within the organization, and physical properties relevant to the performance of engagements; and defines	**Дүрэм** Дотоод аудитын дүрэм нь дотоод аудитын нэгжийн зориулалт , эрх мэдэл , үүрэг хариуцлагыг тодорхойлсон албан ёсны баримт бичиг мөн . Дотоод аудитын дүрэм нь байгууллага дахь дотоод аудитын нэгжийн байр суурь , түүний дотор аудитын гүйцэтгэх удирдлага чиг үүргийнхээ

the scope of internal audit activities.	талаар зөвлөлд тайлагнах харилцааг тогтоож , ажил гүйцэтгэхтэй холбоотой баримт бүртгэль боловсон хүчэнь биет хөрөнгөтэй харьцах эрх олгон, дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхойлно.
Chief audit executive Chief audit creative describes a person in a senior position responsible for effectively managing the internal audit activity in accordance with the internal audit charter and the definition of internal auditing the code of ethics, and the standards. The chief audit executive or others reporting to the chief audit executive will have appropriate professional certifications and qualifications. The specific job title of the chief audit executive may vary across organizations.	**Аудитын гүйцэтгэх удирдлага** Аудитын гүйцэтгэх удирдлага гэж дотоод аудитын дүрэм, дотоод аудитын тодорхойлолт, ёс зүйн дүрэм, стандартуудын дагуу дотоод аудитын нэгжийг үр нөлөөтэй удирдах үүрэг бүхий ахлах албан тушаалтай хүнийг хэлнэ. Аудитын гүйцэтгэх удирдлагад тайлагнах бусад ажилтнууд зохих ёсны мэргэжлийн гэрчилгээ болон мэргэшил эзэмшсэн байна. Аудитын гүйцэтгэх удирдлагын албан тушаалын оноосон нэр байгууллагуудын хувьд өөр өөр байж болно.
Code of ethics The code of ethics of the institute of internal auditors (iia) are principles relevant to	**Ёс зүйн дүрэм** Дотоод аудиторуудын институт (даи)-ийн ёс зүйн дүрэм нь дотоод аудитын

the profession and practice of internal auditing, and rules conduct that describe behavior expected of internal auditors. The code of ethics applies to both parties and entities that provide internal audit services. The purpose of the code of ethics is to promote an ethical culture in the global profession of internal auditing.	мэргэжил ба практикт холбогдолтой зарчмууд болон дотоод аудиторуудын зан төлвийн шаардагдах хэм хэмжээг тодорхойлсон зан суртахууны дүрмүүд юм . Ёс зүйн дүрэм дотоод аудитын үйлчилгээ үзүүлж буй байгууллага , хувь хүний аль алинд хамаарна . Ёс зүйн дүрэм нь дотоод аудитын нийтлэг мэргэжилд ёс суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилготой.
Compliance Adherence to policies, plans, procedures, laws, regulations, contracts, or other requirements.	**Нийцэл** Бодлого, төлөвлөгөө, горим , хууль тогтоомж, дүрэм журам, гэрээ буюу бусад шаардлагуудыг мөрдөх.
Conflict of interest Any relationship that is or appears to be, not in the best interest of the organization. A conflict of interest would prejudice an individual's ability to perfom his or her duties and responsibilities objectively.	**Сонирхлын зөрчил** Байгууллагын ашиг сонирхолд харшилж буй буюу харшлах шинжтэй аливаа харилцаа . Сонирхлын зөрчил нь үүрэг хариуцлагаа бодитойгоор гүйцэтгэх хувь хүний чадварыг алдагдуулахад хүргэдэг .
Consequence **Outcome of an event affecting objectives**	**Үр дагавар** **Зорилгод нөлөө үзүүлэх үйл явдлын үр дүн**

Consulting service Advisory and related client service activities, the nature and scope of which are agreed with the client, are intended to add value and improve an organization's governance, risk management, and control processes without the internal auditor assuming management responsibility. Examples include counsel, advice, facilitation, and training.	**Зөвлөх үйлчилгээ** Шинж чанар, хамрах хүрээг нь захиалагчтай тохиролцдог, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцыг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой зөвлөгөө өгөх болон захиалагчид үйлчилгээ үзүүлэх холбогдох үйл ажиллагаа бөгөөд ингэхдээ дотоод аудитор удирдлагын үүрэг хариуцлага хүлээхгүй. Үүний жишээнд зөвлөгөө, дэмжлэг тусламж, сургалт хамаарна.
Control Any action taken by management, the board, and other parties to manage risk and increase the likelihood that established objectives and goals will be achieved. Management plans, organizes, and directs the performance of sufficient actions to provide reasonable assurance that objectives and goals will be achieved.	**Хяналт** Эрсдэлийг удирдах, дэвшүүлсэн зорилго, зорилтууд биелэгдэх магадлалыг нэмэгдүүлэхийн тулд гүйцэтгэх удирдлага, зөвлөл болон бусад талуудын авсан аливаа арга хэмжээ. Гүйцэтгэх удирдлага зорилго, зорилтууд биелэгдэнэ гэсэн үндэслэлтэй баталгаа өгөх хангалттай арга хэмжээнүүдийг төлөвлөж, гүйцэтгэлийг нь зохион байгуулж, чиглүүлнэ.

Control environment The attitude and actions of the board and management regarding the importance of control within the organization. The control environment provides the discipline and structure for the achievement of the primary objectives of the system of internal control. The control environment includes the following elements: • integrity and ethical values • management's philosophy and operating style. • organizational structure • assignment of authority and responsibility • human resource polocies and practices • competence of personnel.	**Хяналтын орчин** Байгууллага дахь хяналтын ач холбогдлын талаарх зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хандлага ба үйлдлүүд. Хяналтын орчин нь дотоод хяналтын тогтолцооны үндсэн зорилтуудад хүрэх дэг журам , бүтцээр хангана. Хяналтын орчинд дараах бүрэлдэхүүн хэсгүүд багтана : • Шударга ёс ба ёс зүйн үнэт зүйлс • Удирдлагын үзэл баримтлал ба ажлын арга барил • Зохион байгуулалтын бүтэц • Эрх мэдэл , үүрэг хариуцлагын хуваарилалт • Хүний нөөцийн бодлого , практик • Боловсон хүчний ур чадвар .
Control processes The policies, procedures, and control framework, designed to ensure that risks are contained within the risk tolerances established by the risk management process.	**Хяналтын үйл явц** Эрсдэлийн удирдлагын үйл явцаар тогтоогдсон эрсдэлийн тэвчих түвшинд эрсдэлийг байлгах зорилготой хяналтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох бодлого , горим , үйл ажиллагаа.

Engagement A specific internal audit assignment, task, or review activity, such as an internal audit control self - assessment review, fraud examination, or consultancy. An engagement may include multiple tasks or activities designed to accomplish a specific set of related objectives	**Ажил** Дотоод аудит, хяналтын өөрийгөө үнэлэх шалгалт, залилангийн шалгалт буюу зөвлөх үйлчилгээ зэрэг дотоод аудитын тусгайлсан ажил, даалгавар буюу хяналтын үйл ажиллагаа.
Engagement objectives Broad statements developed by internal auditors that de fine intended engagement accomplishments.	**Ажлын зорилтууд** Дотоод аудиторуудын боловсруулсан , ажлын хэрэгжилтийг тодорхойлсон өргөн хүрээтэй мэдэгдлүүд .
Engagement work program A document that lists the procedures to be followed during an engagement, designed to achieve the engagement plan.	**Ажлын хөтөлбөр** Ажлын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор ажлын явцад дагаж мөрдөх горимуудыг жагсаасан баримт бичиг .
External service provider A person of the firm outside of the organization that has special knowledge, skill, and experience in a particular discipline.	**Хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч** Тодорхой салбар ухаанаар тусгай мэдлэг, ур чадвар, туршлага бүхий, байгууллагаас гаднах хүн буюу пүүс.
Fraud Any illegal act characterized by deceit, concealment, or violation of trust. These acts	**Залилан** Хууран мэхлэх, нуун дарагдуулах буюу итгэл эвдэх хэлбэрээр

are not dependent upon the threat of violence or physical force. Frauds are perpetrated by parties and organizations to obtain money, property, or services; to avoid payment or loss of services, or to secure personal or business advantage.	тодорхойлогдох аливаа хууль бус үйлдэл. Эдгээр үйлдэл нь хүчирхийлэл буюу биет хүчний сүрдүүлгээс хамаарахгүй. Байгууллага болон талууд мөнгө, хөрөнгө, үйлчилгээг олж авах; төлбөр буюу үйлчилгээний алдагдлаас зайлсхийх; аль эсвэл хувийн буюу бизнесийн давуу байдлаа хамгаалах үүднээс залилан үйлддэг.
Governance The combination of processes and structures implemented by the board to inform, direct, manage, and monitor the activities of the organization toward the achievement of its objectives.	**Засаглал** Зорилтуудаа биелүүлэхийн тулд байгууллагын үйл ажиллагааг мэдээлэх, чиглүүлэх, удирдах ба хянан шинжлэхээр зөвлөлөөс хэрэгжүүлж буй үйл явц ба бүтцийн нэгдэл.
Impairment Impairment to organizational independence and individual objectivity may include scope limitations, restrictions on access to records, personnel, and properties, and resource limitations (funding).	**Алдагдах** Зохион байгуулалтын хараат бус байдал ба хувь хүний бодитой хандлага алдагдах гэдэгт хувийн сонирхлын зөрчил; хамрах хүрээний хязгаарлалт; бүртгэл, боловсон хүчинтэй танилцах талаарх хязгаарлалт; өмч хөрөнгө

	болон нөөцийн (санхүүгийн) хязгаарлагдмал байдал хамаарна.
Independence The freedom from conditions that threatens the ability of the internal audit activity to carry out internal audit responsibilities in an unbiased manner.	**Хараат бус байдал** Дотоод аудитын нэгж дотоод аудитын үүргээ голч байдлаар хэрэгжүүлэх чадавхид заналхийлсэн нөхцөл байдлаас ангид байх .
Information technology controls Controls that support business management and governance as well as provide general and technical controls over information technology infrastructures such as applications, information, infra structure, and people.	**Мэдээллийн технологийн хяналт** Бизнесийн удирдлага ба засаглалд дэмжлэг үзүүлдэг хяналтууд, мөн түүнчлэн хэрэглээний програм, мэдээлэл, дэд бүтэц болон хүмүүс зэрэг мэдээллийн технологийн дэд бүтцэд тавих ерөнхий ба техникийн хяналтууд.
Information technology governance Consists of the leadership, organizational structures, processes that ensure that the enterprise's information technology supports the organization's strategies and objectives	**Мэдээллийн технологийн засаглал** Үйлдвэрийн газрын мэдээллийн технологи нь байгууллагын стратеги, зорилтуудыг дэмжиж ажиллах нөхцөлийг хангах манлайлал, байгууллагын бүтэц ба үйл явцаас бүрдэнэ.

Inherent risk The probability of loss arising out of circumstances or existing in an environment, in the absence of any action to control or modify the circumstances.	**Уламжлалт \урхагшсан\ аанай эрсдэл** Нөхцөл байдлыг сайжруулаагүй хяналтын ямар нэг арга хэмжээ байхгүйгээс тухайн нөхцөл байдал , эсвэл орчинд үүсч болох алдагдлын магадлал .
Internal audit activity A department, division, team of consultants, or other practitioner (s) that provides in dependent, objective assurance and consulting services designed to add value and improve an organization's operations. The internal audit activity helps an organization accomplish its objectives by bringing a systematic, disciplined approach to evaluate and improve the effectiveness of governance, risk management and control processes.	**Дотоод аудитын нэгж** Байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хараат бус, бодитой баталгаажуулах ба зөвлөх үйлчилгээ үзүүлж буй газар, хэлтэс, зөвлөхүүдийн баг буюу бусад мэргэжилтэн(үүд). Дотоод аудитын нэгж засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцыг үнэлэх, үр нөлөөг нь сайжруулахын тулд системтэй, цэгцтэй арга хандлагыг нэвтрүүлэх замаар зорилтуудаа биелүүлэхэд нь байгууллагад тусалдаг.
International professional practices framework The conceptual framework that organizes the authoritative guidance promulgated by the iia.authoritative guidance is comprised of two categories -	**Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ** Даи-ээс батлан гаргасан захиргааны удирдамжийг зохион байгуулах үзэл баримтлалын хүрээ. Захиргааны удирдамж нь (1)

(1) mandatory and (2) strongly recommended.	албан журмын ба (2) шаргуу зөвлөж буй гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.
Likelihood Chance of something happening	**Магадлал** Ямар нэг зүйл тохиолдох боломж.
Level of risk “magnitude of a risk or combination of risks, expressed in terms of the combination of consequences and their likelihood”	**Эрсдэлийн түвшин** Үр дагавар ба магадлалын хосолмол байдлаар илэрхийлсэн эрсдэлийн хэмжээ.
Must The standards use the word “must” to specify an unconditional requirement.	**Ёстой** Стандартуудад болзолт бус шаардлагыг тодорхойлоход “ ёстой ” гэдэг үгийг хэрэглэсэн .
Objectivity An unbiased mental attitude that allows internal auditors to perfom engagements in such a manner that they believe in their work product and that no quality compromises are made. Objectivity requires that internal auditors do not subordinate their judgment on audit matters to others. Objectivity requires that internal auditors do not subordinate their judgment on audit matters to others	**Бодитой хандлага** Бодитой хандлага нь ажлынхаа үр дүнд итгэн , чанарын доголдол гаргахгүй байхаар ажлаа гүйцэтгэх дотоод олгож буй сэтгэл санааны юм . Бодитой хандлага нь дотоод аудиторууд аудитын асуудлаарх шийдлээ бусдын нөлөөлөлд оруулахгүй байхыг шаардана . Боломжийг аудиторуудад алагчлаагүй хандлага зарчим Бодитой байх нь дотоод аудиторуудад аудитын

Recognition of the definition of internal auditing, the code of ethics, and the standards in the internal audit charter	талаарх өөрсдийн дүгнэлт гаргахдаа бусдын нөлөөн автагдахгүй байхыг шаарддаг . Дотоод аудитын тодорхойлолт , ёс зүйн дүрэм , стандартыг дотоод аудитын дүрмэнд хүлээн зөвшөөрөх
Residual risk The risk remaining after management takes action to re duce the impact and likelihood of an adverse event, including control activities in responding to a risk.	**Үлдэх эрсдэл** Сөрөг үйл явдлын нөлөөлөл ба магадлалыг бууруулахаар удирдлагын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ , түүний дотор эрсдэлд хариу үзүүлэх хяналтын үйл ажиллагааны дараа үлдэж буй эрсдэл .
Risk The possibility of an event occurring that will have an impact on the achievement of objectives. Risk is measured in terms of impact and likelihood.	**Эрсдэл** Зорилтуудын биелэлтэд нөлөө үзүүлэхүйц үйл явдал тохиолдох боломж . Эрсдэлийг нөлөөлөл болон магадлалын талаас нь хэмжинэ .
Risk acceptance Acceptance of residual risks that result from with risk treatment has to take place at the level of the executive management of the organization.	**Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх** Байгууллагын удирдлагын зүгээс тухайн эрсдэлд арга хэмжээ авсны дараа үлдэх эрсдэлийг хүлээн зөвшөөрөх байдал

Risk analysis Process to comprehend the nature of risk and to determine mine the level of risk.	**Эрсдэлийн шинжилгээ** Эрсдэлийн мөн чанарыг ойлгох болон эрсдэлийн түвшинг тодорхойлох үйл явцын дүн шинжилгээ ,
Risk appetite The level of risk that an orgasm is willing to accept. Amount and type of risk that an organization is willing to pursue or retain.	**Эрсдэлийн дуршил** Байгууллага өөртөө хүлээхийг хүсч буй эрсдэлийн түвшин .
Risk assessment Overall process of risk identification, risk analysis and risk evaluation.	**Эрсдэлийн үнэлгээ** Эрсдэлийн тодорхойлолт , эрсдэлийн шинжилгээ болон эрсдэлийн дүгнэлтийн бүхий л үйл явц . Гарах магадлал бүхий нөхцөл , эсвэл үйл явдлын талаар үнэлгээ хийж , мэргэжлийн үүднээс цогц зохицуулалт системт үйл ажиллагаа.
Risk altitude Organization's approach to asses and eventually pursue, retain take or turn away from risk.	**Эрсдэлийн хандлага** Эрсдэлийг тодорхойлох шинжлэх , үнэлэх , эрсдэлээс зайлсхийх , эрсдэлийн арга хэмжээ авах байгууллагын чиглэл .
Risk aversion Attitude to turn away from risk.	**Эрсдэлээс болгоомжлох** Эрсдэлээс зугтаах хандлага ,

Risk avoidance .“informed decision to be involved in, or to withdraw from an activity in order not to be exposed to a particular risk”.	**Эрсдэлээс зайлсхийх** Эрсдэлийг үүсгэж буй үр дагавраас сэргийлэх , нөхцөл байдлаас зайлсхийх .
Risk evaluation process of comparing the results of risk analysis with risk or to determine whether the risk and for its magnitude is acceptable or tolerable.	**Эрсдэлийн үнэлгээний дүгнэлт** Эрсдэл түүний хэмжээ нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх , тодорхой эсэхийг тогтоохын тулд эрсдэлийн шинжилгээний ур дүнг эрсдэлийн шалгууртай харьцуулах .
Risk exposure Extent to which an organization and/or stakeholder is subject to a risk.	**Эрсдэлд өртөх нөхцөл** Тухайн эрсдэл бодитой бий болсноор нөлөөлөл ба магадлалын үр дүнд тухайн байгууллагад үзүүлэх үр дагавар .
Risk identification Process of finding, recognizing and describing risks. Risk identification involves the identification of risk sources and their causes and their potential consequences.	**Эрсдэлийг тодорхойлох** Эрсдэлийг илрүүлэх , хүлээн зөвшөөрөх , тайлбарлах үйл явц . Эрсдэлийн тодорхойлолтонд эрсдэлийн эх үүсвэр , тохиолдол , шалтгаан ба боломжит үр дагавар зэрэг хамаарна .
Rise owner Person or entity with the accountability and authority to manage a risk.	**Эрсдэлийг хариуцагч** Эрсдэлийг удирдах хариуцлага , эрх үүрэг бүхий ажилтан буюу нэгж .

Risk management A process to identify, assess, manage, and control potential events of situations to provide reasonable assurance regarding the achievement of the organization's objectives.	**Эрсдэлийн удирдлага** Байгууллагын зорилтуудыг биелүүлэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахын тулд болзошгүй үйл явдал буюу нөхцөл байдлыг тодорхойлох , үнэлэх , удирдах ба хянах үйл явц .
Risk profile Description of any set of risk.	**Эрсдэлийн дүр зураг , профайл , төрх** Эрсдэлийн иж бүрэн тайлбар , эрсдэлийн иж бүрдлийн тодорхойлолт .
Risk register / risk log Record of information about identified risks.	**Эрсдэлийн бүртгэл** Тодорхойлсон эрсдлүүд, тэдгээрийн ноцтой байдал ба авч буй арга хэмжээг бүртгэсэн үндсэн баримт бичиг .
Risk rating Multiplication of impact and likelihood of risk.	**Эрсдэлийн зэрэглэл** Эрсдэлийн үр дагавар ба магадлалын үржвэр .
Risk response Actions taken to improve opportunities or mitigations to reduce threats.	**Эрсдэлд үзүүлэх хариу үйлдэл** Эрсдэлд авах арга хэмжээ . Боломжийг нэмэгдүүлэх болон аюулыг бууруулах зорилгоор авах арга хэмжээ
Risk retention Acceptance of the potential benefit of gain, or burden of loss, from a particular risk.	**Эрсдэлийг хадгалах** Тухайн эрсдэлээс үүдэх боломжит хохирол , ашгийг хүлээн зөвшөөрөх үйл явц .

Risk sharing Form of risk treatment involving the agreed distribution of is with other parties.	**Эрсдэлийг хуваалцах** Эрсдэлийн тодорхой хэсгийг тараах байдлаар эрсдэлийн үр дагавар болон магадлалыг бууруулах хариу үйлдэл .
Risk source Element which one or combination has the intrinsic potential to give rise to risk.	**Эрсдэлийн эх үүсвэр** Эрсдэл үүсэх бодит боломж .
Risk to/erance Organization's or stakeholder's readiness to bear the risk after risk treatment in order to achieve its objectives.	**Эрсдэл даах түвшин** Тодорхой зорилгод хүрэхийн тулд хүлээн зөвшөөрөх түвшингийн ялгаатай байдал, ирээдүйд хүлээгдэх ашиг тусыг хүртэхийн тулд тухайн этгээд тодорхой түвшинд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хүсэл.
Risk transfer Shifting risk from one party to another.	**Эрсдэлийг шилжүүлэх** Эрсдэлийг бусдад хариуцуулах арга хэмжээ.
Risk treatment Process to modify risk	**Эрсдэлийн арга хэмжээ** Тодорхойлсон эрсдэлийг өөрчлөхөд авах арга хэмжээ,
Should The standards use the word “should” where conformance is expected unless, when ap plying professional judgment, circumstances justify deviation.	**Зүйтэй** Нөхцөл байдал хазайлт гарахад хүргэсэн гэж мэргэжлийн хувьд дүгнэснээс бусад тохиолдолд дагаж мөрдөх шаардлагыг илэрхийлэхэд “зүйтэй” гэдэг үгийг стандартуудад хэрэглэсэн.

Significance The relative importance of matter within the context in which it is being considered, including quantitative and qualitative factors, such as magnitude, nature, effect, elevance, and impact. Professional judgment assissts internal auditors when evaluating the significance or mat ters within the context of the relevant objectives.	**Ач холбогдол** Авч үзэж буй хүрээн дэх асуудлын харьцангуй ач холбогдо. Холбогдол, түүний дотор hар цар хэмжээ, шинж чанар, үр нөлөө, учир холбогдол, нөлөөлөл зэрэг тоон б чанарын хүчин зүйлс. Дотоод аудиторууд холбогдох зорилтуудын хүрээн дэх асуудлын ач холбогдлыг үнэлэхэд мэргэжлийн шийдэл тусална
Standard A professional pronouncement promulgated by the international internal audit standards board that delineates the requirements for perfoming a broad range of internal audit activities, and for evaluating internal audit perfomance.	**Стандарт** Дотоод аудитын өргөн хүрээтэй үйл ажиллагааг гүйцэтгэх ба дотоод аудитын гүйцэтгэлийг үнэлэх шаардлагуудыг тодорхойлсон, дотоод аудитын стандартын зөвлөлөөс батлан гаргасан мэргэжлийн тунхаглал.
Definition of internal audit The definition of internal au diting states the fundamental purpose, nature, and scope of internal auditing	**Дотоод аудитын тодорхойлолт** Дотоод аудитын тодор хойлолт нь дотоод аудитын үндсэн зорилго, шинж чанар, хамрах хүрээг зааж өгнө.
Position papers Position papers assist a wide range of interested parties,	**Байр суурь илэрхийлсэн баримт бичгүүд**

including those not in the in ternal audit profession, in un destanding significant gover nance, risk, or control issues and delineating related roles and responsibilities of internal auditing	Байр суурь илэрхийлсэн баримт бичгүүд нь олон янзын сонирхогч талууд, тэдгээрийн дотор дотоод аудитын мэргэжлийн бус этгээд засаглал, эрсдэл буюу хяналтын чухал асуудлуудыг ойлгох, дотоод аудитад хамаарах үүрэг, хариуцлагыг зааглаж ялгахад нь тусална.
Practice advisories Practice advisories assist internal auditors in applying the definition of internal auditing, the code of ethics, and the standarts and promoting good practices. Practice advisories address internal auditing's approach, method- ologies, and consideration, but do not detail processes or procedures. They include practices relating to: inter national, country, or indus try-specific issues; specific types of engagements; and legal or regulatory issues	**Практик зөвлөмжүүд** Практик зөвлөмжууд нь дотоод аудитын тодорхойлолт, есзүйн дүрэм. Стандартуудыг хэрэглэх болон сайн практикуудыг дэмжихэд нь дотоод аудиторуудад тусална. Практик зөвлөмжид дотоод аудитын арга хандлага, арга ayantbih зүй, харгалзах зүйлсийг авч үзсэн бөгөөд харин үйл явц буюу горимуудыг нарийвчилан заагаагүй. Тэдгээрт олон улсын, улс орны буюу салбарын онцлог асуудлууд, тусгай хэлбэрийн ажлууд, түүнчлэн эрх зүйн буюу зохицуулалтын асуудлуудтай холбоотой практикууд багтана.
Practice guides Practice guides provide de- tailed guidance for conducting internal audit activities. They	Практик зааврууд практик зааврууд нь дотоод аудитын үйл ажиллагааг гүйцэтгэх дэлгэрэнгүй *уд*ирдамжаар

include detailed processes and procedures, such as tools and techniques, programs, and step-by-step approaches, including examples of deliverables	хангана. Тэдгээрт арга хэрэгслэл, арга техник, хөтөлбөр, *үе* шаттай арга хандлага зэрэг нарийвчилсан үйл явц бай горимууд, түүний дотор нийлүүлэх ажлын жиша багтана
Integrity The integrity of internal audi tors establishes trust and thus provides the basis for reliance on their judgement	**Шударга байх** Дотоод аудиторуудын шударга байдал итгэлийг бий болгох бөгөөд улмаар тэдний дүгнэлтэд тулгуурлах үндэслэл болно.
Confidentiality Internal auditors respect the value and ownership of in formation they receive and do not disclose information without appropriate authority unless there is a legal or pro fessional obligation to do so.	**Нууц хадгалах** Дотоод аудиторууд хүлээж авсан мэдээллийн үнэ цэн, өмчлөлд хүндэтгэлтэй хандаж, чингэх хуулийн буюу мэргэжлийн үүрэгтэй л биш бол холбогдох зөвшөөрөлгүйгээр мэдээллийг дэлгэхгүй.
Competency Internal auditors apply the knowledge, skills, and expe rience needed in the perfor mance of internal audit ser Vices	**Ур чадвартай байх** Дотоод аудиторууд дотоод аудитын Үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, туршлагатай байна.
Proficiency Internal auditors must pos sess the knowledge, skills, and other competencies needed to perform their indi vidual	**Чадвар** Дотоод аудиторууд хувийн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, бусад

responsibilities. The in ternal audit activity collective ly must possess or obtain the knowledge, skills, and other competencies needed to perform its responsibilities	чадварыг эзэмших ёстой. Дотоод аудитын нэгж үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, бусад чадварыг хамтдаа эзэмших буюу олж авах ёстой.
Due professional care Internal auditors must the care and skill expected of a reasonably prudent and competent internal auditor. Due professional care does not imply infallibility	**Мэргэжлийн ур дүй** Ухаалаг хэрсүү, чадварлаг дотоод аудиторт байвал зохих анхаарал болгоомж, ур чадварыг дотоод аудиторууд гаргах ёстой. Мэргэжлийн ур дүй гэдэг нь алдаа огт гаргахгүй гэсэн санаа биш юм.
Internal assessments Internal assessments must include ongoing monitoring of the performance of the internal audit activity, and periodic reviews performed through self-assessment or by other persons within the organization with sufficient knowledge of internal audit practices	**Дотоод үнэлгээ** “дотоод үнэлгээнд дотоод аудитын нэгжийн гүйцэтгэлд хийх байнгын хяналт шинжилгээ; өөрийгөө үнэлэх замаар буюу эсвэл дотоод аудитын практикийн талаар Хангалттай мэдлэгтэй байгууллагын бусад ажилтнуудаар үе үе хянуулах ажлууд багтана.
External assessments External assessments must be conducted at least once every five years by qualified, independent reviewe or re-view team from outside the organization.	**Хөндлөнгийн үнэлгээ** “хөндлөнгийн үнэлгээг байгууллагын гаднаас мэргэшсэн, хараат бус хянагч буюу хяналтын багаар наад зах нь таван жил тутам хийлгэх ёстой.

Disclosure of nonconformance When nonconformance with the definition of internal audit ing, the code of ethics, or the standards impact the overall scope or operation of the in ternal audit activity, the chief audit executive must disclose the nonconformance and the impact to senior management and the board.	**Үл нийцлийг танилцуулах** Хэрэв дотоод аудитын тодорхойлолт, ёс дүрэм буюу стандартуудад үл нийцэх байдал нь дотоод аудитын нэгжийн ерөнхий хамрах хүрээ буюу үйл ажиллагаанд нөлөөлж байвал аудитын гүйцэтгэх удирдлага уг үл нийцэл болон түүний нөлөөллийг ахлах удирдлага болон зөвлөлд танилцуулах ёстой
Planning The chief audit executive must establish risk-based plans to determine the priorities of the internal audit activity, consistent with the organization's goal.	**Төлөвлөлт** Аудитын гүйцэтгэх удирдлага байгууллагын зорилгуудад нийт дотоод аудитын нэгжийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох үүднээс эрсдэлд суурилсан төлөвлөгөө гаргах ёстой.
Resource management The chief audit executive must ensure that internal au dit resources are appropri ate, sufficient, and effectively deployed to achieve the ap proved plan.	**Нөөцийн удирдлага** Аудитын гүйцэтгэх удирдлага батлагдсан төлөвлөгөөг биелүүлэхэд дотоод аудитын нөөцийг зохистой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй хуваарилах ёстой
Disseminating results The chief audit executive must communicate results to the appropriate parties	**Үр дүнг түгээх** Аудитын гүйцэтгэх удирдлага үр дүнг холбогдох талуудад мэдээлэх ёстой.

Overall opinions When an overall opinion is issued, it must take into account the expectations of se nior management, the board, and other stakeholders and must be supported by sufficient, reliable, rele useful information,	**Ерөнхий санал дүгнэлт** Ерөнхий санал дүгнэлт гаргаж байгаа бол тэр нь ахлах удирдлага, зерге болон бусад сонирогч талуудын хүсэн хүлээн буй зүйлсийг харгалзсан бөгер хангалттай, найдвартай, учир холбогдолтой, ашигтай мэдээллээр дэмжигдсэн байх ёстой.
Monitoring progress The chief audit executive must establish and maintain a system to monitor the disposi tion of results communicated to management.	**Ахиц дэвшлийг хянан шинжлэх** Удирдлагад танилцуулагдсан үр дүнгийн талаар ямар нэгэн арга хэмжээ авч байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийх тогтолцоог аудитын гүйцэтгэх удирдлага бүрдүүлж, хэвшүүлэх ёстой.
Internal audit charter Formal, written internal audit charter is critical in managing the internal audit activity. The internal audit charter provides a recognized statement for re view and acceptance by management and for approval, as documented in the minutes, by the board	**Дотоод аудитын дүрэм** Дотоод аудитын нэгжийг удирдахад дотоод аудитын албан ёсны, бичмэл дүрэмтэй байх нь чухал. Дотоод аудитын дүрэм нь гүйцэтгэх удирдлагаар хянуулж, Хүлээн зөвшөөрүүлэх болон хурлын тэмдэглэлд баримтжуулсны дагуу зөвлөлөөр батлуулах хүлээн зөвшөөрөгдсөн мэдэгдэл болно.

Quality of communication Communications must be ac curate, objective, clear, concise, constructive, complete, and timely.	**Түгээх мэдээллийн чанар** Мэдээлэл нь алл мадаггүй, бодитой тодорхой, товч, ажил хэрэгч бүрэн, цаг үеэ олсон байх ёстой.
Engagement supervision Engagements must be prop erly supervised to ensure ob jectives are achieved, quality is assured, and staff is developed.	**Ажлыг хянан удирдах** Зорилтууд биелэг, чанар хангагдах боло ажилтнуудыг хөгжүүлэх үүднээс ажлыг сайтар хянан удирдах ёстой.
Criteria for communicating Communications must in clude the engagement's objectives and scope as well as applicable conclusions, recommendations, and action plans	**Мэдээлэлд тавих шалгуурууд** Мэдээлэл нь ажлын зорилтууд, хамрах хүрээ болон дүгнэлт, зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөөг аль болох агуулах ёстой.
Documenting information Internal auditors must docu ment relevant information to support the conclusions and engagement results	**Мэдээллийг баримтжуулах** Дотоод аудиторууд дүгнэлт болон ажлын үр дүнг дэмжих учир холбогдолтой мэдээллийг баримтжуулах ёстой
Errors and omissions If a final communication con tains a significant error or omission, the chief audit ex ecutive must communicate corrected information to all parties who received the original communication	**Алдаа ба орхигдсон зүйлс** Хэрэв төгсгөлийн танилцуулга мэдээлэлд томоохон алдаа гарсан буюу зарим зүйлс орхигдсон бол аудитын гүйцэтгэх удирдлага уг мэдээллийн эх хувийг авсан бүх талуудад залруулсан мэдээллийг хүргүүлэх ёстой.

Direct interaction with the board The chief audit executive must communicate and interact directly with the board	**Зөвлөлтэй шууд харьцах** Аудитын гүйцэтгэх удирдлага зөвлөлтэй шууд мэдээлэл солилцож, харилцан ажиллах ёстой
Hazard Conditions that increase the probability of loss	**Аюулыг үүсгэх хүчин зүйл** Хор хохирлын магадлалыг өсгөх нөхцөлүүд.
Individual objectivity Internal auditors must have an impartial, unbiased attitude and avoid any conflict of interest.	**Хувь хүний бодитой хандлага** Дотоод аудиторууд голч, алагчлалгүй хандлагатай байж, аливаа сонирхолын зөрчлөөс зайлсхийх ёстой.
Impairment to independence or objectivity If independence or objectivity is impaired in fact, or appearance, the details of the impairment must be disclosed to appropriate parties. The nature of the disclosure will depend upon the impairment	**Хараат бус байдал буюу бодитой хандлага алдагдах** Хэрэв хараат бус байдал буюу бодитой хандлага алдагдсан гэж харагдахаар бол энэ талаарх мэдээллийг холбогдох талуудад танилцуулах ёстой. Хэр алдагдсанаас мэдээллийн чанар хамаарна.
Organizational independence The chief audit executive must report to a level within the organization that allows the internal audit activity to fulfill its responsibilities. The chief audit executive must confirm to the	**Зохион байгуулалтын хараат бус байдал** Дотоод аудитын нэгж үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх боломж олгох буй байгууллагын доторх тухайн түвшинд аудитын гүйцэтгэх

board, at least annually, the organizational independence of the internal audit activity.	Удирдлага тайлагнах ёстой. Аудитын гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэгжийн зохион байгуулалтын хараат бус байдлыг зөвлөлд наад зах нь жил тутам нотолж байх ёстой.
Risk management Coordinated activities to di rect and control an organization with regard to risk.	**Эрсдэлийн удирдлага** Эрсдэлтэй холбоотойгоор байгууллагыг удирдах, хянах зохион байгуулалттай үйл ажиллагаанууд.
Risk management Policy statement of the overall in tentions and direction of an organization related to risk management.	**Эрсдэлийн удирдлагын бодлого** Эрсдэлийн удирдлагатай холбоотойгоор байгуул лагын баримтлах хандлага, чиглэлийг тодорхойлсон мэдэгдэл.

A-W

A

Abuse	Эрх мэдлээ урвуулан ашиглах
Abuse of power	Албан тушаалаа урвуулан ашиглах
